



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/027/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот</p> <p>2025 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 260512 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Отгонхорлоо Утас: 261885 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эвиденсе аудит ХХК-ийн захирал: С.Бадамгарав Утас: 99057121 Цахим хаяг: info@evidenceaudit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ц.МИНЖИНХҮҮ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1037
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК нь тайланд онд худалдан авах ажиллагаатай холбоотой нийт 32 тендерийг давхардсан тоогоор 74 удаа тендер шалгуурлалт амжилттай явуулсан ч Зуух №2-ын шаталтын технологийн шинэчлэл хийх зорилгоор 1,650.0 саяыг төсөвлөсөн боловч 2 удаа тендер зарлаж амжилтгүй болсон тул улсын төсвийн тодотголд санал оруулж дээрх төсвийн хүрээнд их засварын ажил хийсэн байна.

Бусад асуудал

Анхаарал татахуйц бусад асуудал гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,262,199,562.22	1,870,103,888.81
1.1.02	Дансны авлага	1,004,744,410.65	1,302,709,431.35
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	2,212,303.00	-
1.1.04	Бусад авлага	273,361,053.23	349,148,929.97
1.1.06	Бараа материал	1,740,723,895.73	2,201,935,368.31
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,120,000.00	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,284,361,224.83	5,723,897,618.44
1.2.01	Үндсэн хөрөнгө	24,519,107,108.98	22,628,227,747.60
1.2.02	Биет бус хөрөнгө	19,333,333,804.44	19,327,994,859.96
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	43,852,440,913.42	41,956,222,607.56
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	48,136,802,138.25	47,680,120,226.00
2.1.1.01	Дансны өглөг	1,329,780,369.84	962,612,318.50
2.1.1.03	Татварын өр	153,739,233.63	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,483,519,603.47	962,612,318.50
2.1.2.01	Урт хугацаат зээл	355,624,655.75	313,741,591.69
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	355,624,655.75	313,741,591.69
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,839,144,259.22	1,276,353,910.19
2.3.01	Өмч: - төрийн	11,797,535,542.78	11,797,535,542.78
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,767,428,001.55	14,767,428,001.55
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	22,774,860,597.52	22,774,860,597.52
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(3,042,166,262.82)	(2,936,057,826.04)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	7,350,290.21	106,108,436.78
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(3,049,516,553.03)	(3,042,166,262.82)
2.3.11	Эздийн өмчийн дүн	46,297,657,879.03	46,403,766,315.81
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	48,136,802,138.25	47,680,120,226.00

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	34,138,542,758.09	37,803,973,037.62
2	Борлуулалтын өртөг	32,217,608,766.90	36,936,776,031.53
3	Нийт ашиг(алдагдал)	1,920,933,991.19	867,197,006.09
4	Түрээсийн орлого	29,476,000.01	40,410,545.55
5	Хүүний орлого	26,552,356.35	174,299,020.16
8	Бусад орлого	304,887,155.08	1,077,842,910.87
8.1	Орлогын дүн	360,915,511.44	1,292,552,476.58
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,090,751,500.54	1,611,758,790.90
11	Санхүүгийн зардал	9,940,208.12	9,102,546.84
12	Бусад зардал	170,505,275.00	417,927,858.42
12.1	Зардлын дүн	2,271,196,983.66	2,038,789,196.16
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	49,780.35	-
17.1	Олз, гарзын дүн	49,780.35	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	10,702,299.32	120,960,286.51
19	Орлогын татварын зардал	3,352,009.11	14,851,849.73
20	Татварын дараах ашиг (алдагдал)	7,350,290.21	106,108,436.78
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	7,350,290.21	106,108,436.78
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	11,797,535,542.78	14,767,428,001.55	22,774,860,597.52	(3,049,516,553.03)	46,290,307,588.82
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	7,350,290.21	7,350,290.21
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	11,797,535,542.78	14,767,428,001.55	22,774,860,597.52	(3,042,166,262.82)	46,297,657,879.03
Залруулсан үлдэгдэл	11,797,535,542.78	14,767,428,001.55	22,774,860,597.52	(3,042,166,262.82)	46,297,657,879.03
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	106,108,436.78	106,108,436.78
2024 оын 12 сарын 31-р үлдэгдэл	11,797,535,542.78	14,767,428,001.55	22,774,860,597.52	(2,936,057,826.04)	46,403,766,315.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	-	-
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	35,424,231,420.98	36,751,020,308.06
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	35,251,152,295.41	35,820,521,618.29
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	54,900,176.75	40,979,594.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	118,178,948.82	889,519,095.77
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	31,432,633,509.71	33,836,913,782.86
1.2.1	Ажиллагчдад төлсөн	9,618,775,221.50	11,814,468,975.75
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,752,131,435.48	3,478,544,260.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	17,161,051,389.02	14,273,852,569.04
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	34,745,930.00	263,165,541.05
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	994,965,650.12
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,687,239,318.14	2,538,201,537.56
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	14,018,360.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	178,690,215.57	459,696,889.34
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,991,597,911.27	2,914,106,525.20
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	26,552,356.35	174,299,020.16
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	26,552,356.35	174,299,020.16
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,037,723,035.33	2,480,501,218.77
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,037,723,035.33	2,480,501,218.77
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,011,170,678.98)	(2,306,202,198.61)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	49,780.35	-
3.1.4	Бусад	49,780.35	-
3.2.5	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	49,780.35	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	980,477,012.64	607,904,326.59
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	281,722,549.58	1,262,199,562.22
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,262,199,562.22	1,870,103,888.81

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 Төлөвлөгөө	2024 Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Боловсруулах	ЦЭХ	сая кВт.ц	80.9	165.6	175.2	9.6	105.8
		ДЭХ	мян.Гкал	10.0	20.4	19.8	(0.6)	97.1
	Эрчим хүч түгээлт	ЦЭХ	сая кВт.ц	70.9	145.2	155.4	10.2	107.0
		ДЭХ	мян.Гкал	142.0	251.6	260.8	9.2	103.7
2	Нийт орлого		сая төг	17,204.5	37,383.6	39,096.5	1,712.9	104.6
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая төг	17,062.6	37,076.3	37,804.0	727.7	102.0
		Үйл ажиллагааны бус орлого	сая төг	141.9	307.3	1,292.5	985.2	420.6
3	Нийт зардал		сая төг	17,486.5	39,568.8	38,975.6	(593.2)	98.5
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая төг	17,448.5	39,374.8	38,557.7	(817.1)	97.9
		Үйл ажиллагааны бус зардал	сая төг	38.0	194.0	417.9	223.9	215.4
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая төг	(282.0)	(2,185.2)	120.9	2,306.1	(5.5)
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая төг	(282.0)	(2,185.2)	120.9	2,306.1	(5.5)
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ноогдох зардал		төг	1.00	1.1	1.0	(0.1)	90.9
7	Нийт авлага		сая төг	1,723.8	1,365.0	1,651.9	286.9	121.0
8	Нийт өглөг		сая төг	1,746.2	1,263.7	1,276.4	12.7	101.0
	Үүнээс:	Урт хугацаат өр төлбөр	сая төг	355.9	313.7	313.8	0.1	100.0
		Богино хугацаат өр төлбөр	сая төг	1,390.3	950.0	962.6	12.6	101.3
9	Нийт ажиллагсад		тоо	265.0	311.0	290.0	(21.0)	93.2
10	Нийт цалингийн сан		сая төг	5,828.4	13,866.9	13,292.2	(574.7)	95.9
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	Цахилгаан	гр/кВт.ц	596.2	615.3	549.4	(65.9)	89.3
		Дулаан	кг/Гкал	197.3	200.6	193.5	(7.1)	96.5

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.